

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА

БАЯНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: [gereltekhhburtgelaudit02@gmail.com](mailto:gereltekhhburtgelaudit02@gmail.com)

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
4. Аудитын тайлан .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Дотоод хяналт.....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
4.4 Материаллаг байдал .....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт .....	15
8.1 Төлбөрийн акт.....	16
8.1 Албан шаардлага.....	17
8.2 Зөвлөмж.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ТБОНӨТХ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Тухай Хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/012  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БЯАНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК-  
ИЙН ЗАХИРАЛ Б.МӨНХГЭРЭЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

19020413

D 2022/2022 он/ALBAN BICHIG

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,927,396.59	3,731,962.82
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	55,434,764.96	27,705,730.33
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	308,665,583.24	300,775,413.59
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>370,027,744.79</b>	<b>332,213,106.74</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	765,488,083.03	729,213,775.17
1.2.2	Биет бус хөрөнгө	206,787,100.00	206,512,100.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>972,275,183.03</b>	<b>935,725,875.17</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,342,302,927.82</b>	<b>1,267,938,981.91</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	243,858,549.06	274,930,175.78
2.1.1.2	Цалингийн өглөг	-	1,763,423.02
2.1.1.3	Татварын өр	177,353,791.92	163,102,323.44
2.1.1.4	НДШ – ийн өглөг	88,049,578.88	177,754,099.04
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>509,261,919.86</b>	<b>617,550,021.28</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	207,952,733.00	207,952,733.00

2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	2,200,000.0
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>207,952,733.00</b>	<b>210,152,733.0</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>717,214,652.86</b>	<b>827,702,754.28</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	946,003,905.78	946,003,905.78
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	119,574,539.03	119,574,539.03
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	203,889,600.00	203,889,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(644,379,769.85)	(829,231,817.18)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>625,088,274.96</b>	<b>440,236,227.63</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,342,302,927.82</b>	<b>1,267,938,981.91</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,163,445,641.90</b>	<b>894,539,237.76</b>
2	Борлуулалтын өртөг	1,078,519,479.67	790,148,174.19
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>84,926,162.23</b>	<b>104,391,063.57</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		238,063,917.53
10	Ерөнхий ба удирдлагын зардал	264,156,814.26	47,946,600.00
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		3,232,593.37
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	454,545.45	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(178,776,106.58)</b>	<b>(184,852,047.33)</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(178,776,106.58)</b>	<b>(184,852,047.33)</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(178,776,106.58)</b>	<b>(184,852,047.33)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(178,776,106.58)</b>	<b>(184,852,047.33)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ нэмэгдэл	Эздийн өмч бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>946,003,905.78</b>	<b>119,574,539.03</b>	<b>203,889,600.00</b>	<b>(644,379,769.85)</b>	<b>604,399,867.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>946,003,905.78</b>	<b>119,574,539.03</b>	<b>203,889,600.00</b>	<b>(644,379,769.85)</b>	<b>625,088,274.96</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(184,852,047.33)	(184,852,047.33)
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>946,003,905.78</b>	<b>119,574,539.03</b>	<b>203,889,600.00</b>	<b>(829,231,817.18)</b>	<b>440,236,227.63</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,307,248,422.00</b>	<b>1,255,012,606.00</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,278,148,375.00	719,300,163.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,530,047.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	21,570,000.00	535,712,443.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,354,758,204.42</b>	<b>1,243,864,786.59</b>
	Ажиллагчдад төлсөн	435,451,367.00	661,416,581.98
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	47,000,000.00	20,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	109,051,514.48	67,690,936.05
	Ашиглалтын зардалд төлсөн	5,061,063.71	9,168,001.70
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	606,532,050.94	385,023,430.54

	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	50,404,714.29	75,012,700.00
	Даатгалын төлбөрт төлсөн	7,530,047.00	191,250.00
	Бусад мөнгөн зарлага	93,727,447.00	25,361,886.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(47,509,782.42)</b>	<b>11,147,819.41</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>13,343,253.18</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		13,343,253.18
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>-</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	23,000,000.00	
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	82,200,000.00	141,614,700.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	82,200,000.00	141,614,700.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	59,200,000.00	141,614,700.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	59,200,000.00	141,614,700.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
		24,509,782.42	2,195,433.77
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>30,437,179.01</b>	<b>5,927,396.59</b>
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>5,927,396.59</b>	<b>3,731,962.82</b>

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		

Бусад орлого	1,163,445,600.00	1,100,000,000.00	894,539,237.76	-	205,460,762.24	81.3%
<b>Нийт дүн</b>	<b>1,163,445,600.00</b>	<b>1,100,000,000.00</b>	<b>894,539,237.76</b>	-	205,460,762.24	81.3%
Цалин хөлс	417,034,967.00	414,492,000.00	415,383,227.00	891,227.00		100.2%
НДШ-ийн зардал	59,020,100.00	53,569,200.00	64,246,300.00	10,677,100.00		119.9%
Албан татвар хураамж /Машины татвар бусад/	4,123,000.00	1,500,000.00	1,334,536.00	-165,464.00		89.0%
Бичиг хэргийн зардал	2,199,300.00	3,180,000.00	2,991,200.00	-188,800.00		94.1%
Ашиглалтын зардал	5,772,200.00	9,000,000.00	6,308,775.95	-2,691,224.05		70.1%
Хангамжийн материалын зардал	245,689,262.00	173,134,000.00	214,403,366.23	41,269,366.23		123.8%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	8,326,000.00	8,326,000.00	9,960,105.00	1,634,105.00		119.6%
Сургалтын зардал	2,914,000.00	6,000,000.00	1,500,000.00	-4,500,000.00		25.0%
Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	130,542,200.00	76,000,000.00	80,775,800.00	4,775,800.00		106.3%
Тогтмол үйлчилгээ, засвар	6,916,100.00	7,008,000.00	8,099,214.82	1,091,214.82		115.6%
Шатахууны зардал	109,368,900.00	105,000,000.00	115,613,300.00	10,613,300.00		110.1%
Даатгалын зардал	470,000.00	500,000.00	326,000.00	-174,000.00		65.2%
Утас, интернэт	1,633,521.00	2,000,000.00	782,175.00	-1,217,825.00		39.1%
Томилолт /унаа, буудал, хоол/	23,416,400.00	7,036,000.00	20,100,600.00	13,064,600.00		285.7%
Хэвлэлийн зардал	389,000.00	389,000.00	372,100.00	-16,900.00		95.7%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	3,073,050.00	1,100,000.00	765,000.00	-335,000.00		69.5%
Банкны үйлчилгээний зардал	98,400.00	100,000.00	97,100.00	-2,900.00		97.1%
Цэвэрлэгээний материалын зардал	2,449,500.00	2,500,000.00	2,112,000.00	-388,000.00		84.5%
Зар сурталчилгааны зардал	855,000.00	641,000.00	300,000.00	-341,000.00		46.8%
Хөдөлмөр хамгааллын зардал	14,825,900.00	11,000,000.00	10,996,000.00	-4,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	274,179,600.00	84,700,000.00	84,307,500.00	-392,500.00		99.5%
Сэлбэг хэрэгсэл	28,925,300.00	18,500,000.00	15,766,000.00	-2,734,000.00		85.2%
Үндсэн хөрөнгө худалдаж авах зардал	0.00	44,500,000.00	22,850,900.00	-21,649,100.00		51.4%
<b>Нийт дүн</b>	<b>1,342,221,700.00</b>	<b>1,030,175,200.00</b>	<b>1,079,391,200.00</b>	<b>130,818,972.50</b>		104.8%

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

**Эрхэм зорилго:** Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлыг гүйцэтгэх, хариуцсан авто замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, эвдрэл гэмтлийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй зорчуулахад оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн дүрэмд “Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар арчлалтын гэрээ”-ний дагуу Баянчандмань-Баруун хараа, Улаанбаатар-Лүн чиглэлд нийт 208 км замын хэмжээнд

зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшдэг байна.

### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийг Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2014 оны 04 дугаар сарын 24-ний өдрийн 217 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” заалттай нийцэж байна.

Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 234 дугаар тогтоолоор Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилсон байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн даргыг сонгосон байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захирлын албан үүрэг гүйцэтгэгчийг томилон, мөн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор албан тушаалыг жинхлэн баталсан байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 01 дүгээр хавсралтаар ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг баталсан байна. Тус тогтоолоор 2021 оны бүтэц орон тоог шинэчлэн, нийт 44 хүний орон тоотой ажиллахаар баталсан байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2021 оны зардлын төсөвт ТУЗ-ийн 10 гишүүнд 2021 онд олгох цалин урамшууллын хэмжээг 41,700.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12-т, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайлан, тодруулгууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,927.4	3,731.9	(2,195.5)
БХХО			
Авлага	55,434.7	27,705.7	(27,729.0)
Урьдчилгаа			

Бараа материал	308,665.6	300,775.4	(7,890.2)
Үндсэн хөрөнгө	765,488.1	729,213.8	(36,274.3)
Биет бус хөрөнгө	206,787.1	206,512.1	(275.0)
Эргэлтийн бус хөрөнгө			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,342,302.9</b>	<b>1,267,938.9</b>	<b>74,364.0</b>
Богино хугацаат өглөг	509,261.9	617,550.0	108,288.1
Урт хугацаат өглөг	207,952.7	207,952.7	-
Урьдчилж орсон орлого			
Хойшлогдсон орлого			
Эздийн өмч	203,889.6	203,889.6	-
Хуримтлагдсан ашиг	(644,379.7)	(829,231.8)	(184,852.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,342,302.9</b>	<b>1,267,938.9</b>	<b>74,364.0</b>

Касс дахь үлдэгдэлд 772.1 мянган төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 2900015353 дугаартай харилцах дансанд байршуулсан 0.44 мянган төгрөг, Хаан банкны 5007905905 дугаартай харилцах дансанд байршуулсан 10.0 мянган төгрөг, Төрийн банкны 102400647605 дугаартай харилцах дансанд байршуулсан 2,949.4 мянган төгрөг, нийт 3,731.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын тооцооны авлага 17,109.1 мянган төгрөг, НДШ-ийн авлага 10,422.9 мянган төгрөг, 1 ажилтнаас авах шатахууны 173.8 мянган төгрөг, нийт 27,705.7 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн байна. Авлагын дансны эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан, найдваргүй авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 300,775.4 мянган төгрөг болж, 7,890.2 мянган төгрөгөөр буурсан нь 20,156.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Тайлант онд бараа материалын данс 948,246.9 мянган төгрөгийн худалдан авалтаар нэмэгдэж, акталж устгасан 20,156.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

Дуусаагүй үйлдвэрлэл дансны 205,555.0 мянган төгрөгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Энэ нь Улаанбаатар Дархан чиглэлийн авто замын шинэчлэлийн зам барих ажлыг хийж бүрэн хийж гүйцэтгээгүй, уг ажил зогссонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс тээврийн хэрэгсэлд их засвар хийсэн 8,791.8 мянган төгрөгөөр, машин механизмд их засвар хийсэн 4,551.5 мянган төгрөгөөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 118 дугаартай тогтоолоор Монголын үнэт цаасны клирингийн төвийн балансаас үнэ төлбөргүй шилжин ирсэн Mitsubishi маркийн УБВ 62-96 дугаартай автобусны 2,200.0 мянган төгрөгөөр, нийт 15,543.3 мянган төгрөгөөр нэмэгджээ. Үндсэн хөрөнгийн данс тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр буурчээ.

Биет бус хөрөнгийн данс санхүүгийн Макс программ хангамжийн элэгдлийн дүнгээр буурсан байна.

Биет бус хөрөнгөнд Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Гонир 3 дугаар багийн Цагаанчулуут төв замын урд байрших 150 м2 талбайтай, замын засвар арчлалт, замын үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жил эзэмших газрын 2,400.0 мянган төгрөг, мөн сумын Гонир 3 дугаар багийн үйлдвэрийн төв замын урд байрших 3.11 га талбайтай замын засвар арчлалт, замын үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жил эзэмших газрын 49,769.6 мянган төгрөг, Төв аймгийн Баянчандмань сумын Чандмань 1 дүгээр багт байрших 14,578 м2 талбайтай, 15 жилийн хугацаатай эзэмших эдэлбэр газрын 23,324.8 мянган төгрөг, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрших 16,052 м2 талбайтай, газрын тосны бүтээгдэхүүн агуулах зориулалтаар 15 жил эзэмших газрын 121,995.2 мянган төгрөг, Төв аймгийн Аргалант суманд байрших 4,000 м2 талбайтай, авто замын засвар, техник механизмын сэлбэг, ажилчдын байр сууцны зориулалтаар 60 жил эзэмших газрын 6,400.0 мянган төгрөг, нийт 203,889.6 мянган төгрөгийн 5 газар бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд ХХОАТ-т өгөх 53,769.6 мянган төгрөг, НӨАТ-т өгөх 105,253.1 мянган төгрөг, НДШ-өгөх 177,755.0 мянган төгрөг, бусад татварт өгөх 4,079.6 мянган төгрөг, ажилчдад өгөх цалингийн өглөг 1,763.4 мянган төгрөг, аудитын үйлчилгээний хөлс 4,000.0 мянган төгрөг, 9 байгууллагад өгөх 236,798.3 мянган төгрөг, 4 хувь хүнд өгөх 18,625.9 мянган төгрөг, үйлдвэрчний хорооны хуримтлалаас өгөх 15,506.0 мянган төгрөг, нийт 617,550.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Өр төлбөрийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2005 онд Кувейтын сангийн зээлээр нийлүүлэгдсэн, эргэн төлөгдөх нөхцөл заагдаагүй 3 ширхэг техникийн 207,952.7 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 288,372.3 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн орлого буурсантай холбоотой байна. Орлого үр дүнгийн тайланд Рашаантын объектыг нефтийн бүтээгдэхүүний агуулахын зориулалтаар түрээслүүлсний орлого 23,636.4 мянган төгрөгийн орлого олсноос ТӨБЗГ-т 40 хувь болох 10,400.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод Автозамын сангаас хариуцсан зам дээр хуваарилагдсан хөрөнгөөр хийгдсэн зам засварын ажлын гүйцэтгэлээрх 756,175.1 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Орлого үр дүнгийн тайлангийн бусад орлогод Рашаантын объектыг нефтийн бүтээгдэхүүний агуулах зориулалтаар түрээслүүлсний 23,236.4 мянган төгрөгийн орлого, Төв аймгийн Сүмбэр сумын авто зам дээр зам засварын ажлын 85,216.5 мянган төгрөгийн орлого, Төв аймгийн 5 суманд зам засварын ажлын 29,911.3 мянган төгрөгийн орлого, нийт 138,364.2 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу 790,148.2 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлагын зардалд 47,946.6 мянган төгрөг, борлуулалт маркетингийн зардалд 238,063.9 мянган төгрөг, бусад зардалд 3,232.6 мянган төгрөг, нийт 1,079,391.3 мянган төгрөгийн зардал бүртгэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,079,391.3 мянган төгрөг болж, 263,739.6 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн орлого буурснаас шалтгаалжээ.

#### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 631 дүгээр тогтоолоор компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,100,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,030,175.2 мянган төгрөгөөр, 62,842.3 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 8 нэр төрлийн 7 ажилд 44,500.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 894,539.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,079,391.2 мянган төгрөгийн зардал гарган, 184,852.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 1. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Нийт орлого</b>	<b>1,163,445.6</b>	<b>1,100,000.0</b>	<b>894,539.2</b>	<b>-205,460.8</b>	<b>81.0</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт					
2	<b>Нийт зардал</b>	<b>1,342,221.7</b>	<b>1,030,175.2</b>	<b>1,079,391.2</b>	<b>49,216.0</b>	<b>105.0</b>
	Үүнээс:					
	а) Ерөнхий ба удирдлагын зардал	264,156.8	341,169.9	286,010.5	-55,159.4	<b>84.0</b>
3	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>-178,776.1</b>	<b>62,842.32</b>	<b>-184,852.0</b>	<b>-247,694.32</b>	<b>-294.0</b>

Нийт орлогын гүйцэтгэл 894,539.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 205,460.8 мянган төгрөг буюу 19 хувиар буурсан нь өөрийн орлого тасарснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,079,391.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 49,216.0 мянган төгрөг буюу 5 хувиар хэтрүүлэн зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 8 нэр төрлийн 7 ажилд өөрийн эх үүсвэрээс 44,500.0 мянган төгрөгийн зардлыг төлөвлөснөөс 5 нэр төрлийн 5 ажилд 15,033.03 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгөөний биелэлт 34 хувьтай байна.

Тайлант онд цэвэр алдагдал 184,852.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 247,694.3 мянган төгрөгөөр буурсан нь орлого 205,460.8 мянган төгрөгөөр буюу 19 хувиар тасарсан, зардал 49,216.0 мянган төгрөгөөр буюу 5 хувиар хэтрүүлэн зарцуулснаас шалтгаалжээ.

Тайлант хугацаанд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг олгоогүй байна.

#### 4. Аудитын тайлан

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалингийн тооцоолол, анхан шатны баримтын бүрдэл, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 55 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Дотоод хяналт

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 08 дугаартай тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог 3 гишүүнтэйгээр томилсон байна. Аудитын хорооны 2021 онд хийсэн ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлого 1,163,900.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 23,278.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 17,458.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 17,890.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 13,418.1 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 5,387.2 мянган төгрөгөөр буурсан байна.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1,

6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянчандмань АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 1,413,064.7 мянган төгрөгийн 50 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,001,191.9 мянган төгрөгийн 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн данстай холбоотой зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	1	-	1	-	-	-	-

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,258,176.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 845.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,114.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,245,016.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Ковид 19 цар тахалтай холбоотой давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэн орлогын данстай холбоотой 243,824.9 мянган төгрөгийн зөвлөмжийг материаллаг бусаар тооцсон болно.

Залруулагдаагүй 10,959.6 төгрөгийн материаллаг алдаа зөрчил нь тогтоосон 13,418.1 мянган төгрөгийн түвшинээс 2,458.5 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулга

Төрийн өмчийн хорооны бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 118 дугаар тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн 2,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмч дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 2 дугаар бүлгийн 2.2.7-д "Аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүйгээр буюу буцалтгүй тусламж, бэлэг, хандиваар үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэн бол хүлээн авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлант үеийн орлого/хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрнө", НББОУС 20-д "Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж"-д заасан аргуудаас сонгон хэрэглэж болно", Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж НББОУС 20-д "Хөрөнгөтэй холбоотой буцалтгүй тусламж" хэсэгт тодорхойлсон "Бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус буцалтгүй тусламжийг багтаасан хөрөнгөтэй холбоотой Засгийн газрын буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого хэлбэрээр эсвэл ,, хэлбэрийн аль нэгээр балансад толилуулна", "буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого болгох ба тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэй, ул үндэслэлтэй сууриар орлого гэж хүлээн зөвшөөрөх", санхүүгийн тайлангийн аудитын "тодруулга ба толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлант үеийн хойшлогдсон орлогоор бүртгэн тайлагнаж, уг дүнгээр төрийн өмч дансыг бууруулан бүртгэж залруулав.

## 8.2 Төлбөрийн акт

Цалинг буруу тооцож олгосонтой холбоотой нийт 845.2 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны цалингаас ХХОАТ чөлөөлөлгүй тооцсоноос 607.6 мянган төгрөгийг илүү, 7-8 сард НДШ-ийг буруу тооцсоноос 22.0 мянган төгрөгийг илүү, нийт 629.6 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д "Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3.5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна", "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтыг үндэслэн акт тогтоов.

2. 26 ажилтны цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлтийг буруу тооцсоноос 205.6 мянган төгрөгийг илүү, 10.0 мянган төгрөгийг дутуу суутгасан.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн акт тогтоов.

### 8.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 16 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 10,114.4 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал ” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлогын данстай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Тайлант 2021 онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр өөрийн орлого болох зам засвар арчлалтын ажлаас олох орлогыг 1,000,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 756,175.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 243,824.9 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар тасарсан байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж

Зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэх, өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх

#### 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 3 ширхэг 94,223.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн

бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **2.2 Өгсөн зөвлөмж:**

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

## **3. Шилэн данстай холбоотой асуудал**

### **3.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 1,413,064.7 мянган төгрөгийн 50 мэдээллийг ил тод байршуулахаас 1,001,191.9 мянган төгрөгийн 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймгийн Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс						Хариуцлага тооцох			
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийг Засгийн газрын сан дансанд бүртгэсэн	Үнэ төлбөргүй шилжин ирсэн үндсэн хөрөнгийг хойшлогдсон орлого дансанд бүртгэх, хөрөнгийн ашиглалтын хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх	1	2,200.0	1	2,200.0								
2	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Өөрийн орлогын бүрэн төвлөрүүлж ажиллаагүй	Үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлант үеийн хойшлогдсон орлогоор бүртгэн тайлагнаж, уг дүнгээр төрийн өмч дансыг бууруулан бүртгэж залруулав.	1	243,824.9								1	243,824.9	
3	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Цалинг буруу тооцоолж олгосон	Цалингаас суутган тооцсон татвар шимтгэлийг хууль журамд заасны дагуу зөв тооцоолон бүртгэх, татварын хуулийн хэрэгжилт ханган ажиллах	1	845.2			1	845.2						
4	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх	1	-								1	-	
5	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, И баримтаар нотлогдоогүй	Худалдан авалт хийсэн тухай бүр И баримтаар баталгаажуулан данс бүртгэлд тусгах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, татварын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	1	10,114.4					1	10,114.4				
<b>ДҮН</b>					5	256,984.5	1	2,200.0	1	845.2	1	10,114.4			2	243,824.9
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
6	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨА-2022/08/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроон мэдээлсэн	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлж хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах	1	1,001,191.9								1	1,001,191.9	
<b>ДҮН</b>					1	1,001,191.9								1	1,001,191.9	
<b>НИЙТ ДҮН</b>					5	1,258,176.4	1	2,200.0	1	845.2	1	10,114.4			3	1,245,016.8